

**Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит
сонгуульд бие даан нэр дэвшигч Т.Төрбатын мөрийн хөтөлбөр**

1. Дундговь аймагт “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байгуулах асуудлыг санаачилж, Төрийн албыг иргэдэд ээлтэй, нээлттэй байх орчин нөхцөлийг бүрдүүлж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэлийн хяналтын тогтолцоог сайжруулж, иргэдийн хариуцлагатай хяналтын тогтолцоог бий болгоно.
3. Орон нутгийн бизнес эрхлэгчдийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагаанд давуу байдалтай оролцуулан үйл ажиллагааг нь бодлогоор дэмжинэ.
4. Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, сонгэн, секц, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжиж, улс болон бүсийн чанартай олимпиад тэмцээнийг аймагт тогтмол зохион байгуулах ажлыг санаачилна.
5. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг иргэд, орон нутгийн төрийн бус байгууллага хамтран гүйцэтгэдэг механизм бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ. Байгалийн өнгөт чулуу ашиглан гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ашиг орлогоо нэмэгдүүлэх бодлогоор иргэдийг дэмжиж, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.
6. Хүүхдийн паркийн үйл ажиллагааг өргөтгөн хөгжүүлж, хүүхэд залуучууд болон ахмад настнууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ
7. Аймгийн төвийн гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх, цэвэр ус, бохир зайлуулах шугам татах, гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, хүүхэд залуучууд, ахмадуудын тоглоомын талбай, ахмадын амрах талбай байгуулж тав тухтай, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.
8. Боржигон багийн Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсгийн барилгыг нэгдсэн халаалтад холбох асуудлыг шийдвэрлэж, төрийн албан хаагчийн ажиллах орчныг сайжруулна.
9. Аймгийн төвийн айл өрх болон гудамж талбайн хог хаягдлыг ангилж, хаях боломжтой хогийг савжуулах, хогийн машины тоог нэмэгдүүлж эрүүл, цэвэр орчин бүрдүүлэх, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэх иргэд, ААН-д орон нутгаас бодлогын дэмжлэг үзүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:

Т.Төрбат

